



**1. Төслийн товч танилцуулга**

- 1.1 Төслийн зорилго
- 1.2 Төслийн байршил
- 1.3 Ордын уул геологийн нөхцөл
- 1.4 Хөрс хуулалт, элс олборлолтын ажлын техник технологийн сонголт

**2. Төсөл хэрэгжих орчны өнөөгийн байгаль орчны төлөв байдал**

- 2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

**3. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

**4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

- 4.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах төлөвлөгөөний биелэлт
- 4.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт
- 4.3 Усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт
- 4.4 Ан амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

**5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт**

**6. Биологийн олон янз байдалыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

**7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

**8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт**

**9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

**10. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

**11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

**12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

**13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

**14. Аймаг нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээний биелэлт**



=

## 1. Төслийн товч танилцуулга

### Хүснэгт №1

№	Төслийн товч танилцуулга	
1	Төслийн нэр :	Алтны шороон орд
2	Төсөл хэрэгжүүлэгч:	"Жи энд Юу Голд" ХХК
3	Төслийн дугаар :	2017/Т-046
4	Улсын бүртгэлийн дугаар :	9011156145
5	Регистрийн дугаар :	2675471
6	Хаяг, байршил :	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 1-р 10 мянгат, 5-18
7	Утас :	70174070
8	Төслийн байршил	
9	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос баруун тийш 900 км-т Гурванбулаг сумаас зүүн хойд зүгт 25 км-т, байр зүйн зургийн L-47-30 хавтгайнуудад байрладаг	
10	X:84982.34	Y:234378.04
11	X:85550.23	Y:234376
12	X:84945.63	Y:234472.97
13	X:85556.73	Y:235738.40

### Төслийн зорилго 1.1


Баянхонгор аймгийн Гурван булаг сумын нутагт байрлах MV-021800 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Ихэрийн амны алтны шороон ордыг ашиглаж, эрдэс баяжмал үйлдвэрлэснээр, улсынхаа валютын нөөцийг өсгөхөд хувь нэмэр оруулах, аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн чадавхаа нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, уулын үйлдвэрийн ашиглалт, баяжуулалтын технологи, уул геологийн нөөцийн судалгааны туршлага хуримтлуулах, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй бөгөөд алт олборлох, боловсруулах техник технологийг сайжруулж, уул уурхайн салбараас эдийн засагт оруулах өгөөжийг дээшлүүлэх олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг өсгөхөөр төрөөс авч хэрэгжүүлж байгаа хүрээнд ордын талбайд олборлох, үйл ажиллагааг явуулж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэнэ.

### Төслийн байршил 1.2:

#### Хүснэгт №-2 Төслийн талбайн солбилцолын цэгүүд

Д/д	өргөрөг			уртраг			талбайн хэмжээ. Га	олгосон огноо
1	98°	48'	33.42''	47°	14'	17.67''	77.09	2010 оны АМГ-ын даргын 127 тоот тушаал
2	98°	48'	6.42''	47°	14'	17.67''		
3	98°	48'	6.42''	47°	15'	1.67''		
4	98°	48'	33.42''	47°	15'	1.67''		

Зураг №1. Төслийн талбайн байршил



Ихэрийн ам алтны шороон орд нь Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос 870 км орчим, Баянхонгор аймгийн төвөөс баруун хойш 250 км-т, Гурванбулаг сум нь ордын талбайгаас зүүн тийш 24 км-т байрлана.

*Төсөл хэрэгжих суурь нөхцөл байдал 1.3:*

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт орших “Ихрийн ам” нэртэй тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2006 оны 09 дугаар сарын 12-ны өдөр АМГ-ын ГУУКА-ны даргын шийдвэрээр MV-021800А тоот 77.09 га талбай бүхий Ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Жи энд Юу голд” ХХК-д 30 жилийн хугацаагаар олгожээ.

Ихрийн ам нэртэй алтны шороон ордод 2002 онд нарийвчилсан хайгуул хийж, гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд ЭБЭХЯ, ЭБМЗ-н 2002 оны 02-р сарын 04-ны (дүгнэлтийн дугаар 07) хурлаар хэлэлцэн нөөцийг баталсан.

Өмнөх онуудад үйл ажиллагаа явуулаагүй удсан байсан тул Техник эдийн засгийн үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

АМХЭГ-ын даргын тушаалаар MV-021800А тусгай зөвшөөрлийн талбайн 77.09 га талбайд



= химийн цэврээр 653,71 кг алтны нөөц бүртгэгдсэн байна. Үүнээс урд онуудад олборлосон металл 218,4 кг, үлдэгдэл нөөц 435,3 кг-аас ЗС,4С блокуудыг олборлож 78.67 кг металл олборлохоор 2021 оны төлөвлөгөөг боловсруулан ажилласан.

### 1.3 Ордын уул геологийн нөхцөл

Ордын талбай нь Монгол-Өвөр Байгалийн атираат мужийн Баянхонгорын бүтэц хэлбэршлийн бүсийн хойд хэсэгт байрлана. Талбайн геологийн хэлбэршлийн бүсэд дунд кембрий доод ордовикийн субдукцын бүсийн аккрицын шаантгын гаралтай Загийн серийн флиш маягийн терриген хурдас, түүнийг зүссэн хожуу пермийн Хангайн цогцолборын 3-р фазын гүний чулуулаг, гол хөндийн гаралтай орчин үеийн дөрөвдөгчийн сэвсгэр хурдсууд хөгжсөн байна.

Давхарга зүй : Дунд Кембрий-доод ордовикийн Загийн сери нь талбайн ихэнх хэсгийг бүрхсэн байх ба ерөнхийдөө баруун хойш  $270^{\circ}$ - $300^{\circ}$ -ын чиглэлээр сунаж тогтсон байдаг. Загийн серийн занар, элсэн чулуу, алевролит, бүхий хурдсыг анх 1966 онд илрүүлж, Баянхонгорын серийн дээр нийцлэг байдлаар байрлаж буй гэж доод палеозойд хамааруулсан байдаг. Дараагийн үеийн геологичид үүнийг хүлээн зөвшөөрч Загийн серийн хурдас нь ногоон, ногоон саарал заримдаа цайвар саарал өнгөтэй, кварц-серицит, кварц-хлорит, серицит-хлориттой шаварлаг занар, кварц плагиоклазтай янз бүрийн ширхэгтэй элсэн чулуу, алевролит, хааяа гравелит, хөрзөн чулуу зэргээс тогтоно. Талбайд Загийн серийн 3 зузаалаг тархсан байна.

Доодзузаалаг: Энэ хурдсанд ногоон саарал, цайвар-ногоон өнгөтэй серицит-плагиоклазтай занар, шаварлаг занар-филлит, заримдаа филлит-элсэн чулууны салаавчилсан багц үелэлүүдтэй. Эдгээр нь тектоник магмын нэрвэлтэд автаж хожуу пермийн интрузив биетүүдээр зүсэгдсэн байна. Ерөнхий зузаан нь 1500 м байдаг.

Дундзузаалаг: Хурдас нь судалгааны талбайн төв хэсгээр доод зузаалгийн дээр синклиналь атираа үүсгэж 14 км урт, 1,5-2,0 км өргөн баруун хойш чиглэлтэй сунасан структур үүсгэнэ. Гол төлөв ногоовтор, хар-саарал, цайвар өнгөтэй, холимог найрлагатай гравелит, нарийн ширхэгтэй элсэн чулуу, шаварлаг занар, хааяа ногоон занараас бүрдэнэ. Зузаан нь ойролцоогоор 1300 м.

Дээд зузаалаг: Талбайн төв болон хойд хэсгээр зонхилон тохиолдоно. Энэ зузаалагт ногоон саарал, цайвар-ногоон, том том ширхэгт кварц-хээрийн жоншны найрлагатай элсэн чулуу, алевролитын зузаан үелэлүүд болон хөрзөн чулуу гравелитын жижиг үе мишилүүдээс бүрддэг. Энэ зузаалаг нь хожуу пермийн Хангайн цогцолборын 3-р фазын



=  
жигжиг боржингийн биетүүдээр зүсэгдэж нилээд хувиралд орсон байдаг. Дээд зузаалгийн зузаан нь ойролцоогоор 1200 м байна.

**Дөрөвдөгчийн хурдас:** Энэ хурдас нь хөндий, уулын бэл хажуу хормойг бүхэлд нь хучиж тогтсон байна. Гарал үүслийн хувьд алювийн гаралтай /Q<sub>IV</sub>/, дээд-орчин үеийн дөрөвдөгчийн /Q<sub>III-IV</sub>/, делюви-пролювийн гаралтай хурдсууд тархсан байдаг.

Дээд-орчин үеийн хурдас нь талбайд хамгийн өргөн тархсан. Энэ хурдсанд Өвөр хөшөөтийн хөндийн татмын дээрхи 1-р дэнжийн хэмжээнд илрэх голын болон хажуу хормойн хурдсуудыг хамааруулах бөгөөд эдгээр нь ерөнхийдөө саарал, бор-саарал, бараан өнгийн элсэн чулуу, боржингийн янз бүрийн найрлагат сэвсгэр хурдаснаас тогтох ба дээд хэсэгтээ муу мөлгөржсөн том хэмхдэст дайрга, элс элсэнцэр, шавранцар байдлаар илэрнэ. Зузаан нь 15-28 м байна.

Энэхүү хурдсанд үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий алтны шороон хуримтлал агуулагдах ба насыг нь түүний геологи, геоморфологийн онцлогийг үндэслэн дээд дөрөвдөгчид хамааруулсан болно. Энэ хурдасны алттай давхарга нь хучаас хурдасны саарал өнгийн элсэрхэг дүүргэгчтэй, сайн мөлгөржсөн хайрга, хайрганцараас эрс ялгарах шаргал, улбар шаргал өнгийн шаварлаг-элсэрхэг дүүргэгчтэй сайн мөлгөржсөн хайрга, хайрганцараас тогтдог онцлогтой.

Орчин үеийн аллювийн гаралтай хурдас нь талбайн хэмжээнд бага тархалттай, голын хөндий, сайруудын татмын хэмжээнд илрэх голын, гол-хормойн гаралтай хурдсуудыг хамааруулж байгаа ба эдгээр нь тодорхой хэмжээний алтны шороон хуримтлал агуулах ба энэ нь доор байрлах алттай үндсэн давхаргын угаалга, зөөгдлийн бүтээгдэхүүн болох юм. Энэ хурдас нь урсгалын дагуу сайн ялгарсан үеллэг тогтоцтой, янз бүрийн хэмжээний хэмхдэсүүд агуулсан элс, элсэнцэр, хайрганцараас тогтсон ба гол төлөв хэмхдэсүүд нь өнцгөлсөн байдаг.

**Гүний чулуулаг:** Хожуу Пермийн Хангайн цогцолбор /Pz/: Хангайн цогцолборын боржин нь талбайн төв хэсгээр жигжиг биетүүд үүсгэж Загийн серийн дунд-дээд зузаалгийн хурдсуудыг зүсэж илэрсэн байдаг. Боржингийн биетүүдийн хамгийн том нь 4,5км х 2,3км байх ба дунджаар 1,5км х 0,5-1,0км талбайтай байна. Хожуу пермийн Хангайн серийн 3-р фазийн жигжиг биетүүд нь том, дунд, жигжиг ширхэгт, ягаан саарал, саарал, бор шаргал өнгөтэй, сул шигтгээлэг лейкоборжин, боржин-амфиболит, биотитой боржингууд юм. Боржингууд нь хил заагийн орчимдоо хүчтэй хувиралд орсон байдаг ба ялангуяа төмөржилт, пиритжилт, цахиржилт, березитжилт хүчтэй явагдсан байдаг. Загийн серийн хурдсууд нь мөн дээрхи хувирлуудад орж бор-саарал шаравтар



=  
өнгөтэй болсон байх ба хил зааг орчмын кварцын нарийн судланцруудад алтны үндсэн илрэлүүд үүссэн байдаг.

**Тектоник:** Талбай нь төв Азийн атираат системийн Монгол-Өвөр Байгалийн мужийн Баянхонгорын атираат бүсэд оршиж байна. Энэ атираат бүс нь каледоны үед дээд рифей-түрүү палезойн үеийн хурдас хуримтлалаас бүрдэх ба энд хамгийн ихээр хөгжсөн нь дунд кембрий-доод ородовикийн Загийн серийн хурдас юм. Дараагийн үе шат болох дунд-кембрий доод-ордовикын үед флиш маягийн элсэн чулуу, занарын маш зузаан хурдсууд хуримтлагджээ. Дунд-түрүү палезойн төгсгөлөөс Баянхонгорын бүсийн захын хэсгүүд суултад орж, ингэснээр өргөгдлүүд үүсч, Хангайн геосинклиналь бүсээс бүлэг хагарлуудаар тусгаарлагдсан байна.

Герцины цаг үед буюу түрүү пермийн төгсгөлөөс тектоник бүтцийн хувьд үндсэн өөрчлөлтүүд гарч гүний түрэлтүүд хүчтэй явагдсан ба үүний дүнд структурын том жижиг бүрдлүүд үүсч энэ бүс нутагт өндөр уулсын гадаргуунууд бий болсон байна.

Орчин үед тектоник-магмын дахин сэргэлтээр баруун хойш чиглэлийн гүний хагарлуудын үр дүнд рифтын бүсүүд үүссэн нь хожуу пермийн настай хангайн цогцолборын жижиг биетүүд үүсэх урьдчилсан нөхцөл болжээ. Герцины цаг үед хайгуулын талбайн орчимд өөр хурдас хуримтлал явагдаагүй байна.

Дөрөвдөгчийн үеийн идэвхжилийн структур талбайн хэмжээний хуримтлалд хөгжиж буй хөндийнүүдийн хөгжил хөдөлгөөний явцад үүсч, хуримтлагдаж, зөөгдөж байгаа бэлийн, дэнжийн, хажуу хормойн гаралтай хурдсууд орох ба ихэнхдээ зүүн хойш чиглэсэн байдаг. Талбай нь Гурванбулагийн, хойд Баянхонгорын гүний хагарлаар баруун талаараа, зүүн талаараа Байдрагийн гүний хагарлаар зааглагдана.

**Геоморфологи:** Талбайн хэмжээнд гадаргууг нь 1-рт идэгдэл-тектоникийн, 2-рт идэгдэл-хуримтлалын гэсэн үндсэн 2 төрлийн гадаргууг ялгасан.

Идэгдэл-тектоникийн төрлийн гадаргууд өндөр уулсын тэгш оройтой идэгдэл хэрчигдэлд гүн автсан, шовх оройтой эрчимтэй идэгдэж хэрчигдсэн эгц хажуутай уулсын гадаргуунууд хамаарна. Идэгдэл хуримтлалын төрлийн гадаргуу нь ихэвчлэн зүүн хойш чиглэсэн хагарлуудаар үүссэн голын хөндий, доош суусан хэсгүүд, уулын хажуу энгэр, дэнжүүд илэрдэг.

**Гидрогеологи:** Өмнөхсудлаачдын үзэж байгаагаар талбайн гидрогеологийн нөхцөл нь геоморфлогийн онцлог, геологийн тогтоц, жилд унах хур тундасны хэмжээнээс хамаарч харилцан адилгүй тогтоогдсон байна. Талбайд гидрогеологийн хувьд сэвсгэр



=  
хурдасны тунамал- хувирмал чулуулгийн болон боржин чулуулгийн уст бүрдэлүүд байдаг байна.

### **Ордын уул техникийн нөхцөл**

Тухайн орд нь дунд гүний, мөнхийн цэвдэгтэй, олборлоход хүнд, дунд зэргийн агуулгатайгаас гадна хот болон аймгийн төвөөс алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн бүс нутагт оршино.

Ордын дундаж агуулга талбайн нийт тархалтаараа жигдэвтэр, харин ордын баруун хэсэгтээ босоо тархалтаараа доошлох тусам ихсэж байгаа нь тогтоогдсон байна. Ордын талбайн газрын гадаргаас доош 3.0 м-ээс эхлэн олон жилийн цэвдэгтэй. Ордын нөөцийн тооцооны хил заагаас баруун тийш хуулсан хөрсийг овоолох, зөөж тээвэрлэхэд лицензийн талбай хангалттай байсан.

Хөрсийг хуулж дууссаны дараа ашигт давхаргыг шууд олборлох боломжгүй юм. Учир нь алт агуулсан элс нь мөн адил хэмжээний цэвдэгтэй тул шууд угааж олборлоход металлын хаягдал ихэснэ. Иймд элсийг овоолго хийж, гэссэний дараа угааж Баяжуулж ажилласан.

Ашигт давхарга нь 6.3-20м гүнд олон жилийн цэвдэгт байрладаг 15-25%-н шаварлаг хольцоор сулавтар барьцалдсан 40-50%-н хайргархаг хольц агуулсан элсэнцэр, хайрга, дайрга, ул чулуулгийн өгөршлийн хэмхдэс бүхий III-V-р зэргийн хатуулагтай сэвсгэр хурдсаас тогтоно. Хуулах хөрсний 1/3 хувийг ус эзэлдэг тул олборлолтын явцад ус зайлуулах, шүүх асар их ажил хийгддэг. Үүнээс шалтгаалсан уулын ажлын хүндрэл ихтэй. Ашигт давхарга нь гүн ухагдсан цүнхээл, үүр маягаар тогтоогүй нь ул хөрсний цэвэрлэгээ хийхэд хүндрэлгүй.

Олон жилийн цэвдэгтэй шороон ордыг ашиглах онцлог тал нь тухайн орд хөлдүү төлөвт оршдогоос гадна үйлдвэр байрласан газар нутгийн цаг уурын хүндрэлтэй нөхцөл болон ордын байрших онцлогоос шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл ашиглалтын маш эрчимтэй явуулах, улирлын чанартай ажлыг зохион байгуулах ил уурхайн техникт тавигдах онцгой шаардлага гарч ирдэг. Учир нь цэвдэгтэй орд нь техникийн элэгдэл хорогдлыг үлэмж хэмжээгээр ихэсгэдэг.

Энэ орд нь усны хүндрэлтэй боловч дээрх усны асуудлыг ашиглалтын зөв технологи хэрэглэснээр олборлолт явуулж буй хэсэгт усны хүндрэл үүсгэхгүйгээр карьерын дотор болон гадна хуримтлуулснаар элс угаах технологийн усны хэрэглээг хангах боломж олгож буй давуу талтай юм.

Улирлын чанартай ажилд баяжуулах хэсэг буюу элс угаалтын ажил хамаарах бөгөөд энэ нь цаг уурын нөхцөлөөс шалтгаалахаас гадна цэвдэгтэй хөлдүү элсийг баяжуулахаас өмнө



=  
зайлшгүй гэсгээх шаардлага гардагтай холбоотой юм. Иймд улирлын чанартай ажлыг зохион байгуулах ажил энд чухал юм.

#### **1.4 Хөрс хуулалт, элс олборлолтын ажлын техник технологийн сонголт**

Ордыг ил уурхайн аргаар ашигласан ба уурхайн хөрс хуулалтын ажлыг экскавацлалт дотоод овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэсэн. Хөрс хуулалтын ажлыг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, дотоод овоолго хийх орон зай бий болох хүртэл гадаад овоолго хийж энэхүү орон зай бий болсон үед ордын үйл ажиллагаа зогстол дотоод овоолго хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Элс олборлолтын ажлыг өрөмдлөг-тэсэлгээ-экскавацлалт-авто тээвэр-агуулах гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэсэн. Элс олборлолтын ажлыг экскаватор болон автосамосвалын тусламжтайгаар угаах тоног төхөөрөмжийн ойролцоо овоолго хийсэн.

Уулын ажлын үндсэн техникт коматцу D-375A, D-155A, D-65E, Cat D-8 зэрэг бульдозер-ууд, коматцу PC-1250 PC-600, CAT-349 экскаваторуудыг уул техникийн тухайн нөхцөлд газар дээр нь тааруулан сонгож ажиллуулсан. Тусгайлан зассан талбайд хөрс элсийг бульдозероор овоолж, экскаватороор хөрсийг талбайгаас гаргах, элсийг угаах төхөөрөмжинд өгөх ажлыг мөн хослуулан хийсэн хаягдал багатай баяжуулалтын системийг сонгож ажилласан. Угаах төхөөрөмжийн элс хүлээн авах бункерийг элсээр хангах ажлыг ойрын зайд бага оврын CAT Д-8 бульдозероор түрж, шаардлагатай тохиолдолд экскаватор, ачигч машин ашиглан ажиллана.

Энэ жилийн хувьд 7 дугаар сараас хойш тухайн бүс нутагт их хэмжээний үер устай бороо ойр ойрхон давтамжтай орж байснаас уул техникийн нөхцлийг хүндрүүлж, зарим үзэгдэх орчин хязгаарлагдсан үед уурхайн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч ажилласан.

#### **2. Төсөл хэрэгжих орчны өнөөгийн байгаль орчны төлөв байдал**

Баянхонгор аймаг нь газарзүйн байршлын хувьд Монгол орны хэнтий нуруу ба түүний гол салбаруудын тойрогт оршдог. Уур амьсгалын мужлалаар сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй хуурай сэрүүн мужид багтана. Жилийн дундаж температур  $0,4^{\circ}$  хэм, дулааны улиралд  $12,6^{\circ}$  хэм, өвлийн улиралд  $-11,8^{\circ}$  хэм байдаг ба жилийн дундаж хур тунадас 20,3 мм. Баянхонгор гадаргын усны нөөц нь 0,20 км<sup>3</sup> байна. Тус аймгийн Гурванбулаг сум нь Номхон далайн ай савын түр урсгал бүхий гол горхитой мужид багтдаг бөгөөд тогтмол урсгалтай гол мөрөн, нуур байхгүй боловч толгодын хоорондох жижиг горхи байдаг. Ургамалжилтын хувьд тал хээрийн, хуурай хээрийн, нутгын, цөлөрхөг хээрийн ургамал зонхилох ба карбонатлаг хар хүрэн хөрстэй. Монгол дорнод хэв хамаарагдах Харгана бүхий жижиг бутлаг үетэн хиаг-хялганат, хиаг сөөгт, чулуусаг алаг өвст ботуульт, алаг өвст хялганат тархсан. Амьтны аймгийн хувьд Буга, бор гөрөөс, тарвага, үнэг, чоно,





=  
мануул байхаас гадна цөөн тооны, шилүүс байдаг. 137,6 мянган малтай. Дагуур огдой, Тоодог, тогоруу, улаан хошуут жунгаа, шар шувуу, болжмор, алаг шаазгай, тас, бүргэд зэрэг шувууд бий.

### **Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл**

**Байгаль орчинд:** Төслийн үйл ажиллагаанаас 42 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 3 буюу 7,1% нь “бага” 19 буюу 45,2% нь “дунд” 18 буюу 42,8 нь их, 2 буюу 4,8% нь маш их гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Эндээс үзэхэд төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ дундаас их хэмжээнд байхаар байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ агаарын чанарт 16% газрын гадарга, хэвлийн 19%, хөрсөн бүрхэвч 17% газрын доорх усанд 14%, ургамлын нөмрөгт 17%, амьтаны аймагт 17% гэсэн үзүүлэлт гарч байгаа ба газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл илүү байна.

#### **Байгаль орчинд:**

##### *Сөрөг нөлөөллийг бууруулах арга*

- Тоосжилт үүсгэх гол эх үүсвэрүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн эхний үе шатанд төлөвлөн, цаашид энэхүү сөрөг нөлөөллийг бууруулсан арга, туршлага, болон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж ашиглах.
- Хөрс хуулсан талбай болон эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрт нь үржил шимт хөрсөөр бүрхэж ургамалжуулах.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх.
- Овоолгыг салхинд хийсч, тоос дэгдэхээс урьдчилан сэргийлж, овоолго түүний ойр орчимд салхины хурд бууруулах хаалт хийх.
- Овоолгыг цаг тухайд нь тэгшилж, нягтруулах, хэрэгжүүлэх, чийглэж гадаргууг дагтаршуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болох олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх.
- Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн тогтмол засвар, үйлчилгээг хийж байх.
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
- Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгслийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техникт эвдрэл гарна) хяналт тавих,
- Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах хэрэгтэй.



- Түр хадгалах байр болон засварын хэсэгт бий болох ахуйн болон шатахуун, тослох материалын хаягдал үерийн усаар зөөгдөж хөрс бохирдохоос сэргийлж, зориулалтын саванд цуглуулах, төв суурин газарт зөөвөрлөж зайлуулах шаардлагатай.
- Усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж ажилласан.

**Хүний эрүүл мэндэд:** Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, тэсэлгээ, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдал зэрэг уурхайн ажилчид, орон нутгын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний үүрэгт хамаарагдаж байна.

#### *Сөрөг нөлөөллийг бууруулах арга*

Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардалгуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

**Нийгэм эдийн засагт:** Төсөл хэрэгжих суманд ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах, төсөл хэрэгжих хугацаант аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгэмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласаны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

### **2.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд**

Уурхайн олборлолтын ажил явуулах үед газар орчны эвдрэл тодорхой хэмжээгээр гарна. Уулын ажил явуулах талбайд тоног төхөөрөмжүүдийг байрлуулж, барилга байгууламжуудын байршлыг өөрчлөгдөхөөргүй, байнгын байрлах газар оновчтой байршуулж үйлдвэр зохион байгуулалтын ажлыг зохих журмын дагуу явуулсан.

Ордод олборлолтын ажил явуулснаар ойр орчмын унаган төрх бага зэрэг алдагдахаас өөр орон нутагт үзүүлэх сөрөг нөлөө бага боловч доорх арга хэмжээнүүдийг 2021 оны үйлдвэрлэлийн явцад авч хэрэгжүүлсэн.

Үүнд:

- Уулын ажлыг газар эдэлбэрийн хуулийн дагуу аймаг, сум, багийн засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн талбайд зөвхөн зураг төсөлд тусгагдсан хил хязгаарын дотор явуулсан.
- Хуулсан хөрсийг аль болох дотоод овоолгод хийхээр тооцож уулын ажлыг хийсэн. Угаах төхөөрөмжөөс гарч байгаа үйлдвэрийн хаягдал усыг эргүүлэн ашиглаж, эргэлтийн усан санг байгуулж ажилласан.

=

- Ихрийн аманд урсгал усгүй тул элс угаасан хаягдал усыг хуучин гольдрол руу тунааж эргэлтэнд оруулан ажилласан.
- Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтэд зориулагдсан замыг зөвхөн нэг маршрутаар хийсэн ба зөвхөн хийсэн замаараа олборлолтоо явуулсан.
- Уурхайн машин, техникүүдийг шатахуунаар цэнэглэх, засвар хийх цэгтэй болж зөвхөн тухайн цэгт шатахуун түгээж засвар хийж хэвшүүлсэн.
- Ургамлын хар шороон хөрсийг тогтоогдсон хэмжээний зузаантайгаар олборлолт явагдах талбайгаас хуулан авч, тусгай овоолгод байрлуулсан.
- Хөрсийг гадаад овоолгоос болон уулын ажлын ахилтын үеийн хөрсийг ашиглагдсан хоосон орон зайд бульдозероор түрж, машинаар зөөвөрлөн авчирч тараан тэгшилсэн.

### Зураг №2 Уурхайн план зураг



### 3. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа нөлөөллийг бууруулах улмаар арилгах нь компанийн гол үүрэг бөгөөд 2021 онд байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэлд “Жи энд Юу Голд” ХХК-аас орд газрын байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах, орчны хяналт явуулахад шаардагдах зардлыг Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа түлш, шатахуун, материалын үнэ, ажил үйлчилгээний хөлсний тариф ба жишиг үнийг баримжаалан шинэчлэн тооцоолсон болно.



**Үйл ажиллагааны хүрээ**

Төслийг хэрэгжүүлэх явцад мөрдвөл зохих үндэсний болон олон улсын бодлого, хууль журмыг нэгтгэн оруулсан. Төсөл хэрэгжүүлэгч “Жи Энд Юу Голд” ХХК нь эдгээр бодлого, хууль журмыг сахин биелүүлж төслөөс учрах аливаа сөрөг нөлөөллийг Монгол улсын хууль, журам дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хамгийн бага төвшинд, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй ажилласан.

**Хүснэгт №3 хэрэгжүүлсэн хуулиуд**

Д/д	Хуулийн нэр	Батлагдсан он
1	Агаарын бохирдолын төлбөрийн тухай хууль	УИХ. 2010
2	Агаарын тухай хууль /шинчилсэн найруулга/	УИХ. 2012
3	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль /шинчилсэн найруулга/	УИХ. 2006
4	Ариун цэврийн тухай хууль	УИХ. 1998
5	Ашигт малтмалын тухай хууль /шинчилсэн найруулга/	УИХ. 2006
6	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	УИХ. 2014
7	Байгалийн нөөц ашигласны Төлбөрийн тухай /шинчилсэн найруулга/	УИХ. 2012
8	Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хууль	УИХ. 2012
9	Байгаль орчныг хамгаалах тухай	УИХ. 1995
10	Газрын тухай /шинчилсэн найруулга/	УИХ. 2002
11	газрын төлбөрийн тухай	УИХ. 1997
12	Газрын аюулгүй байдлын тухай	УИХ. 1999
13	Гол Мөрний урсац бүрэлдэх эх. Усны сан бүхий хамгаалалтын бүс. Ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх . Ашиглахыг хориглох тухай хууль	УИХ. 2009
14	Замын хөдөлгөөний аюулгүй байдал тухай	УИХ. 2015
15	Захиргааны хариуцлагын тухай	УИХ. 2016
16	Ургамал хамгааллын тухай	УИХ. 2007
17	Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль	УИХ. 2019
18	Усны тухай /шинчилсэн найруулга/	УИХ. 2020
19	Хог хаягдалын тухай хууль	УИХ. 2012
20	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Эрүүл ахуйн тухай	УИХ. 2008
21	Хөдөлмөрийн хууль	УИХ. 1999
22	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай	УИХ. 2012

**Хүснэгт №4 хэрэгжүүлсэн хуулиуд**

№	стандартын нэр	Дугаар
1	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	MNS 4585:206
2	Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга	MNS 5365:2005



3	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5885:2008
4	Хог хаягдалыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011
5	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъё. Тодорхойлолт	MNS 5914:2008
6	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал	MNS 5915:2008
7	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал	MNS 5915:2008
8	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт	MNS 5916:2008
9	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага	MNS 5917:2008
10	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага	MNS 5918:2008
11	Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм	MNS 0017-0-0-06:79
12	Байгаль орчны хамгааллын стандартын систем. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм	MNS 4219:92
13	Байгаль орчны хамгаалал. Усан мандал газрын доорх усны бохирдлоос хамгаалах	MNS 3342:1982
14	Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага	MNS 4244:94
15	Галын аюултай бодис. Материал ангилал	MNS 4284:2006
16	Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж байгуулга бариллага байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлийн зайлашгүй байх шаарлага норм	MNS 5566:2005
17	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390:2004
18	Ундны ус . Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт	MNS 0900:2010
19	Аж ахуйн нэгж. Байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлийн зайлшгүй байх шаардлага норм	MNS 5566:2005
20	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS 5150:2002
21	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй цахилгааны аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй ерөнхий шаардлага	MNS 4968:2000
22	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5850:2019
23	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх. Зөөх ачааны массын дээд хэмжээ	MNS 4970:2000
24	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5079:2001



25	ХХСС. Хэт өндөр дуу. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 0012:1016
26	Хөдөлмөрийн аюулгүй байдал үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллангаа. Хамгаалах газардуулга тэглэлт	MNS 5146:2002
27	Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага	MNS 4931:2000
28	Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага	MNS ISO 13688:2000
29	Авто тээврийн хэрэгсэлийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин хэмжих арга хэмжээ	MNS 0017-5-1-21:1992
30	Газар шорооны ажлын машин. Ашиглалт ба засвар үйлчилгээ-Механик бэлтгэх сургалт	MNS ISO 4653:1998
31	Газар шорооны ажлын машин. Хөрс ухаж тээвэрлэх. Бульдозер. Нэр томъёо ба техникийн шаардлага	MNS ISO 6747:2005
32	Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага	MNS 4943:2015

Хүснэгт №5 хэрэгжүүлсэн хуулиуд

№	Дүрэм журмын нэр	Батлагдсан он/дугаар
1	Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлсэн эргэн. Аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журам	Засгийн газрын 1998 оны 95 дугаар тогтоолын хавсралт
2	Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах. Нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам	Байгаль орчны сайдын 2007 оны 6 дугаар тушаал
3	Орчны бохирдолыг бууруулах. Уул уурхайн нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Байгаль орчны сайдын албан даалгавар
4	Иргэн аж ахуй нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах тайлагнах журам	БОАЖЯ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр /А-618/ тушаал
